



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/У98

Улаанбаатар хот

**Нийслэлийн Байгаль орчны газрын
данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгдчийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 12,600,000.0 /арван хоёр сая зургаан зуун мянган/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн Байгаль орчны газар /Э.Баттулга/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Байгаль орчны газар /Э.Баттулга/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050001497

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 11 сарын
25 өдрийн 01/492 тушаалын хавсралт

Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Байгаль орчны газар

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар, үзүүлэлт	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны		Эх үүсвэр
						Нэгжийн үнэ	Бүгд үнэ	
1	Минжний дүдэр	Төв Азийн минж	2019	ш	9	1,400,000.00	12,600,000.00	Бүртгэлтэй минж зулзагалсан
Мал, амьтаны дүн							12,600,000.00	
НИЙТ							12,600,000.00	